



ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Дорноговь аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2019 оны
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: ДГА-2020/01/СТА-ТЭЗ

Цахим хуудас: www.audit.mn	Дарга, тэргүүлэх аудитор: Ч.Ариунаа Утас: 70522734 Цахим хаяг: ariunaa.ch@audit.gov.mn Аудитын менежер: Ч.Хэрлэнчимэг Утас: 70503020 Цахим хаяг: kherlenchimegch@audit.gov.mn Ахлах аудитор: О.Нарангарав Утас: 70523020 Цахим хаяг: narangarav.o@audit.gov.mn Аудитор: У.Оюунтүлхүүр Утас: 70523020 Цахим хаяг: oyuntulkhuur.u@audit.gov.mn Аудитор: Б.Уранбилэг Утас: 70523020 Цахим хаяг: uranbileg.b@audit.gov.mn Аудитор: Т.Мөнхтогтох Утас: 70523020 Цахим хаяг: munkhtogokht@audit.gov.mn
Сайншанд	
2020 он	

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

<p><u>Тайланг бэлтгэсэн:</u></p> <p>Дорноговь аймаг дахь Төрийн аудитын газар</p> <p>Дарга, тэргүүлэх аудитор Ч.Ариунаа</p> <p>Аудитын менежер</p> <p>Ч.Хэрлэнчимэг</p> <p>Ахлах аудитор: О.Нарангарав Аудитор: У.Оюунтүлхүүр Б.Уранбилэг Т.Мөнхтогтох</p> <p>2020 оны 04 сарын 28</p> <p>Аудитын тайлан, дүгнэлттэй холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 70522734, 70503020 дугаарын утас, dornogovi@audit.gov.mn хаягаар харилцана уу.</p> <p>ХАЯГ: Дорноговь аймаг Сайншанд сум Төрийн өмчийн 3 дугаар байр.</p>	<p style="text-align: center;">ТАЙЛАНГИЙН АГУУЛГА</p> <p>Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй4</p> <p>Үндсэн мэдээлэл5</p> <p>БҮЛЭГ 1. АЙМГИЙН 2019 ОНЫ ТӨСВИЙГ 21.1 САЯ ТӨГРӨГИЙН АЛДАГДАЛТАЙ БАТАЛСАН БАЙНА.</p> <p>1.1. Сангийн яамны хянасан орон нутгийн төсвийн суурь орлогыг аймгийн ИТХ-аар 11,178.0 сая төгрөгөөр нэмэгдүүлж, 2 төрлийн орлогыг төсвийн хязгаараас бууруулж баталсан байна.</p> <p>1.2. Орон нутгийн төсвийн суурь зардлыг Сангийн яамны хянасан хязгаарыг баримтлахгүйгээр 4,819.8 сая төгрөгөөр нэмж баталсан байна.</p> <p>1.3. Төсвийн нэмэлт өөрчлөлтөөр орон нутгийн орлогын эх үүсвэрийг 876.9 сая төгрөгөөр, зардлыг 898.0 сая төгрөгөөр тус тус нэмэгдүүлсэн байна.</p> <p>1.4. Аймгийн төсвийн нийт орлогыг 71,330.2 сая төгрөг, нийт зардлын төсвийг 71,351.3 сая төгрөгөөр баталсан байна.</p> <p>БҮЛЭГ 2. ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ОРЛОГО НИЙТ ДҮНГЭЭРЭЭ 1,479.5 САЯ ТӨГРӨГӨӨР ДАВЖ, ТӨСВИЙН ЗАРЛАГЫН ГҮЙЦЭТГЭЛ 68.0 ТЭРБУМ ТӨГРӨГ БАЙНА.</p> <p>2.1. Татварын болон татварын бус орлогыг төвлөрүүлэх нөөц боломжийг бүрэн ашигласан байна.</p> <p>2.2. Орон нутгийн төсвийн зардлын гүйцэтгэл 22,882.7 сая төгрөг байна.</p> <p>2.3. Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас 1,251.8 сая төгрөгийн орлогын шилжүүлгийг дутуу олгосон байна.</p> <p>2.4. Нэмэлт санхүүжилтийн дансаар хөрөнгө оруулалтын зарим ТАХ-ний санхүүжилтийг олгосон байна.</p> <p>Аудитын дүгнэлт25</p> <p>Зөвлөмж26</p>
---	--

ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

НАНБХАСЗАСЗУСТ	Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай
ХАХНХС	Хүн ам, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд
БСШУС	Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд
ТШЗ	Төсвийн шууд захирагч
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
АИТХ	Аймгийн иргэдийн Төлөөлөгчийн Хурал
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчийн Хурал
ОНХНС	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан
ГХБХБГ	Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар
ГБХЗХГ	Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газар
НББ	Нягтлан бодох бүртгэл
ОНХО	Орон нутгийн хөрөнгө оруулалт
ТЗШ	Тусгай зориулалтын шилжүүлэг
ЕБС	Ерөнхий боловсролын сургууль
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
ХК	Хувьцаат компани
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
СХС	Сум хөгжүүлэх сан
ААНБ	Аж ахуй нэгж, байгууллага
ЭМД	Эрүүл мэндийн даатгал
ЭМДС	Эрүүл мэндийн даатгалын сан
ЭМТ	Эрүүл мэндийн төв
ААНОАТ	Аж ахуй нэгжийн орлогын албан татвар
АТБӨЯХАТ	Авто тээвэр болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар

Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй

1. Аудитын нэр:

Дорноговь аймгийн 2019 оны төсвийн гүйцэтгэл

2. Аудитын код:

ДГА-2020/01/СТА-ТЕЗ

3. Аудит хийх бүрэн эрх, үндэслэл:

Аудитыг Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.4, Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.1 дэх заалтыг үндэслэн Төрийн аудитын тухай хуулийн 18.2 дугаар зүйлд заасан төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийж гүйцэтгэв.

4. Аудитын зорилт:

Дорноговь аймгийн 2019 оны төсвийн орлого, зарлагыг үндэслэлтэй төлөвлөж, хэрэгжүүлсэн эсэх, гүйцэтгэлийг үнэн зөв илэрхийлсэн эсэхийг шалган, дүгнэлт, зөвлөмж боловсруулан, дүнг холбогдох байгууллага, албан тушаалтнуудад танилцуулах, олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилт оршлоо.

- Орон нутгийн төсвийн орлого, зарлагыг үндэслэлтэй төлөвлөсөн эсэх
- Орон нутгийн төсвийн орлогыг бүрэн төвлөрүүлсэн эсэх
- Орон нутгийн төсвийн зарлагын гүйцэтгэл бодитой байна эсэх

5. Аудитын хамрах хүрээ:

Монгол Улсын 2019 оны төсвийн тухай хууль, улсын төсвөөс авсан санхүүгийн дэмжлэг, орлогын шилжүүлэг, орон нутгийн төсвийн орлогын бүрдүүлэлт, төсвийн орлого, зарлагыг баталсан аймаг, сумдын ИТХ-ын тогтоол, 2019 оны төсвийн гүйцэтгэлийн тайлан тэнцэл, судалгаа, мэдээлэл болон бусад холбогдох баримтыг хамруулав.

6. Аудитын арга зүй:

Аудитыг гүйцэтгэхэд Төрийн хяналт шалгалтын стандарт, санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагыг ашиглан холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга, лавлагаа авах, тайлан баримт материалд тулган баталгаажуулалт, дүн шинжилгээ хийж, судалгаа хийж, аудитын хөтөлбөр, горимын дагуу нотлох зүйл цуглуулан дүгнэлт, зөвлөмж, боловсруулав.

7. Аудитад ашигласан хууль тогтоомж, шалгуур үзүүлэлт:

Монгол улсын Төсвийн тухай хууль, 2019 оны Төсвийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Төрийн аудитын тухай хууль, Татварын багц хуулиуд болон холбогдох бусад хууль тогтоомж, эрх зүйн актууд, аймаг, сумдын ИТХ-ын тогтоолуудыг шалгуур үзүүлэлт болгон ашиглалаа.

8. Аудит хийх багийн бүрэлдэхүүн, хугацаа:

Аудитыг Дорноговь аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ч.Ариунаа удирдаж, аудитын менежер Ч.Хэрлэнчимэг явцын болон чанарын хяналтыг хэрэгжүүлэн, Санхүүгийн аудитын албаны ахлах аудитор О.Нарангарав, аудитор У.Оюунтүлхүүр, Б.Уранбилэг, Т.Мөнхтогтох нар 2019 оны 04 дүгээр сарын 01-ны өдрөөс 04 дүгээр сарын 20-ны хооронд гүйцэтгэв.

9. Үндсэн мэдээлэл

Дорноговь аймгийн 2019 оны төсвийн нийт орлого нь татварын ба татварын бус орлого, орлогын шилжүүлэг, төсөвт байгууллагуудын өөрийн орлого, сум хөгжүүлэх сангийн орлого болон нөхөн сэргээлтийн тусгай дансанд байршуулсан барьцаа хөрөнгөөс бүрдсэн байна.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвийн нийт орлого 104.9 хувь, нийт зарлага 95.6 хувийн биелэлттэй тайлагнагдсан байна.

Аймгийн төсвийг аймаг, сумын ИТХ, ЗДТГ, Засаг даргын нөөц сан, орон нутгийн хөгжлийн сан, нийгмийн халамжийн сан, сум хөгжүүлэх сан, нөхөн сэргээх данс, орон нутгийн төсвийн байгууллагууд, соёлын төв, тусгай зориулалтын шилжүүлгээр санхүүждэг байгууллага зэрэг нийт 175 байгууллага, сангуудын үйл ажиллагааг санхүүжүүлэхэд зарцуулсан байна.

2019 онд аймгийн төсөвт 2 удаа, сумдын төсөвт тус бүр 1-2 удаа тодотгол хийж, эцсийн дүнгээр нийт орлого 71,330.2 сая төгрөг, зарлагыг 71,348.3 сая төгрөгөөр төлөвлөж, нийт санхүүжилт 67,881.4 сая төгрөг буюу 95.1 хувь, нийт зардал 68,042.7 сая төгрөг буюу 95.4 хувийн гүйцэтгэлтэй, 3,305.6 сая төгрөгөөр хэмнэлттэй тайлагнасан байна.

БҮЛЭГ 1: АЙМГИЙН 2019 ОНЫ ТӨСВИЙГ 21.1 САЯ ТӨГРӨГИЙН АЛДАГДАЛТАЙ БАТАЛСАН БАЙНА.

1.1 Сангийн яамны хянасан орон нутгийн төсвийн суурь орлогыг аймгийн ИТХ-аар 11,178.0 сая төгрөгөөр нэмэгдүүлж, 2 төрлийн орлогыг төсвийн хязгаараас бууруулж баталсан байна.

1.1.1. Дорноговь аймгийн 2019 оны төсвийн суурь орлогыг Төсвийн тухай хуулийн 57, 58 дугаар зүйлийн 58.2-д заасан нөхцөл, чиг үүрэг, Сангийн сайдын 2012 оны 244 дүгээр тушаалаар баталсан "Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам", аймгийн 2019 оны төсвийн хүрээний мэдэгдэл болон холбогдох хууль тогтоомжийг үндэслэн боловсруулжээ.

1.1.2. Сангийн яамнаас орон нутгийн төсвийн суурь орлогыг 20,012.5 сая төгрөгөөр хянасан ба аймаг, сумдын ИТХ-ын тогтоолоор 11,178.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэн 31,190.5 сая төгрөгөөр баталсан байна.

Орон нутгийн төсвийн суурь орлого

Хүснэгт №1

/ сая төгрөгөөр/

Орлогын нэр төрөл	Сангийн яамны хянасан орлого	Аймгийн ИТХ-аар баталсан	Зөрүү
ТАТВАРЫН ОРЛОГО	18,176.9	21,342.9	3,166.0
1.ОРЛОГЫН АЛБАН ТАТВАР	14,230.7	14,957.3	726.6
1.1.Хүн амын орлогын албан татвар	15,230.7	15,817.3	586.6
1.1.1. Цалин хөлс түүнтэй адилтгах бусад орлого	12,100.0	12,100.0	0.0
1.1.2. Үйл ажиллагааны орлогын татвар	2,187.5	2,065.0	-122.5
1.1.5. Хөрөнгө борлуулсны татвар	0.0	221.4	221.4
1.1.6. Шууд бус орлогын татвар	943.2	1,430.9	487.7
1.1.7. Хувь хүний орлогын албан татварын буцаалт	-1,000.0	-860.0	140.0
2.ӨМЧИЙН АЛБАН ТАТВАР	1,095.1	1,426.5	331.5
2.1. Үл хөдлөх хөрөнгийн албан татвар	438.1	685.2	247.1
2.2. Галт зэвсгийн албан татвар	31.9	31.3	-0.6
2.3. АТБӨЯХ-ийн албан татвар	625.0	710.0	85.0
3. ШИЛЖҮҮЛГИЙН ОРЛОГО	0.0	0.0	0.0
3.1. Нэмэгдсэн өртгийн албан татвар	0.0	0.0	0.0
4. БУСАД ТАТВАР	2,851.1	4,959.1	2,107.9
4.1. Улсын тэмдэгтийн хураамж	1,570.0	1,827.5	257.5
4.2. Ан агнах зөвшөөрлийн хураамж	134.8	134.8	0.0
4.3. Ашигт малтмал ашигласны төлбөр	0.0	0.0	0.0
4.4. Газрын төлбөр	436.4	480.0	43.6
4.5. Рашаан, ус ашигласны төлбөр	142.5	251.2	108.7
4.6. Хог хаягдлын үйлчилгээний хураамж	363.5	381.0	17.5
4.7. Ашигт малтмалаас бусад баялаг	0.0	0.0	0.0
4.8.Түгээмэл тархацтай ашигт малтмал	204.0	354.7	150.7
4.9. Бусад төлбөр хураамж	0.0	1,530.0	1,530.0
ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,835.6	9,847.6	8,012.0
1. Түрээсийн орлого	35.0	27.0	-8.0
2. Хүү торгуулийн орлого	671.4	2,123.9	1,452.5
3. Татварын бус бусад орлого	314.2	1,166.8	852.6
3.1. Нэр зааж ангилагдаагүй орлого	300.0	1,071.8	771.8
3.2. Төсөвт байгууллагын өөрийн орлого	14.2	95.0	80.8
V.ХӨРӨНГИЙН ОРЛОГО	815.0	6,530.0	5715.0
1. Үндсэн хөрөнгө борлуулсны орлого	15.0	30.0	15.0

2. Дуудлага худалдааны орлого	800.0	6,500.0	5,700.0
Орон нутгийн төсвийн суурь орлого	20,012.5	31,190.5	11,178.0

Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.1-д “Төсвийн ерөнхийлөн захирагч нь жилийн төсвийн хязгаарт багтаан төсвийн төслийг боловсруулах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ” гэж заасан байна.


Гэтэл орон нутгийн суурь орлогыг жилийн батлагдсан төсвийн хязгаарыг баримтлахгүйгээр галт зэвсгийн албан татварыг 0.6 сая төгрөгөөр, түрээсийн орлогыг 8.0 сая төгрөгөөр тус тус бууруулж баталсан байна.

1.1.3. Орон нутгийн төсвийн суурь орлогын 68.4 хувийг татварын орлогоор, 31.6 хувийг татварын бус орлогоор бүрдүүлэхээр төлөвлөсөн байна.

1.1.4. Сангийн яамны хянасан болон аймгийн ИТХ-аас баталсан суурь орлогын төлөвлөгөөг өмнөх онтой харьцуулахад суурь орлогыг 2017 онд 9,441.1 сая төгрөгөөр, 2018 онд 7,875.5 сая төгрөгөөр, 2019 онд 11,178.0 сая төгрөгөөр нэмж баталсан байна.

1.1.5. Орон нутгийн татварын болон татварын бус орлогын төлөвлөгөөг өмнөх онуудтай харьцуулахад 2019 онд дунджаар 20.2 хувиар нэмэгдсэн үзүүлэлттэй байна.

Татварын орлогын төлөвлөгөөг өмнөх онтой харьцуулахад 2018 онд 806.1 сая төгрөгөөр, 2019 онд 269.2 сая төгрөгөөр нэмэгдүүлсэн нь хувь хүний орлогын албан татварын өсөлт голчлон нөлөөлсөн бөгөөд энэ нь цалингийн өсөлт болон хувь хүний орлогын албан татварын буцаалт буурсантай холбоотой байна.



Орлогын төлөвлөгөө

Татварын бус орлогын төлөвлөгөөг өмнөх онтой харьцуулахад 2018 онд 821.5 сая төгрөгөөр нэмэгдсэн нь торгуулийн орлогын өсөлтөөс, 2019 онд 2,569.3 сая төгрөгөөр нэмэгдсэн нь торгуулийн орлого, газрын дуудлага худалдааны орлогын өсөлтөөс шалтгаалжээ.

1.2. Орон нутгийн төсвийн суурь зарлагыг Сангийн яамны хянасан хязгаарыг баримтлахгүйгээр 4,819.8 сая төгрөгөөр нэмж баталсан байна.

1.2.1. Сангийн яамнаас орон нутгийн төсвийн суурь зарлагыг 19,702.2 сая төгрөгөөр хянасан бөгөөд аймаг, сумдын ИТХ-ын тогтоол болон тодотголоор суурь зардлыг 3,807.9 сая төгрөгөөр нэмэгдүүлэн, 23,510.1 сая төгрөгөөр баталсан байна.

Орон нутгийн төсвийн суурь зарлага

Хүснэгт №2

сая төгрөгөөр

№	Байгууллагын нэр	Сангийн яамны хянасан зарлага	Аймгийн ИТХ-аас баталсан зарлага	Зөрүү
1	Аймаг, сумдын ИТХ	1,173.9	1,902.4	728.5
2	Аймаг, сумдын ЗДТГ	6,718.1	8,160.0	1,441.9
3	Захирагчийн ажлын алба	0.0	262.0	262.0
4	Санхүүгийн хяналт аудитын алба	127.1	163.9	36.8
5	Орон нутгийн өмчийн газар	131.9	148.7	16.8
6	БОАЖГ	434.0	404.7	(29.3)
7	Халамжийн сан	119.8	119.8	0.0
8	Хот тохижилт	882.2	1,748.3	866.1
9	Биеийн тамир спортын газар	402.8	361.8	(41.0)
10	Соёлын байгууллага	1,647.1	1,842.1	195.0
11	Соёлын байгууллагуудын байр ашиглалтын зардал	756.4	774.4	18.0
12	ТЗШ-ын байгууллагуудын байр ашиглалтын зардал	5,558.4	4,921.6	(636.8)
13	Засаг дарга ерөнхий данс	1,750.5	2,663.5	913.0
14	Замын-Үүд сумын ОНХО	0.0	36.9	36.9
Дүн		19,702.2	23,510.1	3,807.9

Сангийн яамны хянасан удирдлагыг хэрэгжүүлэх зардлыг 3,425.1 сая төгрөгөөр, соёлын үйлчилгээний байгууллагын зардлыг 213.0 сая төгрөгөөр, хот тохижилтын зардлыг 866.1 сая төгрөгөөр, харьяа төсөвт байгууллагын зардлыг 315.6 сая төгрөгөөр тус тус нэмэгдүүлсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.1-д “Төсвийн ерөнхийлөн захирагч нь жилийн төсвийн хязгаарт багтаан төсвийн төслийг боловсруулах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ” гэж заасныг зөрчсөн байна.

Харин байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх зардлыг 29.3 сая төгрөгөөр, ТЗШ-ийн байгууллагын байр ашиглалтын зардлыг 636.8 сая төгрөгөөр, нийтийн биеийн тамирын зардлыг 41.0 сая төгрөгөөр, бусад урсгал зардлыг 304.9 сая төгрөгөөр тус тус бууруулан баталсан байна.

1.3 Төсвийн нэмэлт өөрчлөлтөөр орон нутгийн орлогын эх үүсвэрийг 876.9 сая төгрөгөөр, зардлыг 898.0 сая төгрөгөөр тус тус нэмэгдүүлсэн байна.

Орон нутгийн суурь орлого, зарлагын өөрчлөлт.

1.3.1. Аймаг, сумдын ИТХ-ын тогтоолоор 2019 онд 2 удаа төсөвт нэмэлт өөрчлөлт хийж, орон нутгийн суурь орлогыг 31,190.5 сая төгрөг, орон нутгийн суурь зарлагыг 23,510.1 сая төгрөгөөр баталж, нийт 7,680.4 сая төгрөгийн үндсэн тэнцлийн ашигтай байхаар төлөвлөсөн байна.

Орон нутгийн үндсэн тэнцэл

Хүснэгт №3

сая төгрөгөөр

Үзүүлэлт	Анхны Батлагдсан төсөв	Төсвийн нэмэлт өөрчлөлт	Зөрүү
Орон нутгийн суурь орлого	31,190.5	-	31,190.5
Татварын орлого	27,842.9		27,842.9
Татварын бус орлого	3,347.6		3,347.6
<i>Орон нутгийн суурь зардал</i>	<i>23,100.7</i>	<i>409.4</i>	<i>23,510.1</i>
Аймаг сумдын ИТХ	1,833.1	69.3	1,902.4
Аймаг сумдын ЗДТГ	7,845.6	314.4	8,160.0
ЗАА	254.3	7.7	262.0
СХАА	158.0	5.9	163.9
ОНӨГ	139.6	9.1	148.7
БОАЖГ	404.7	-	404.7
Халамжийн сан	119.8	-	119.8
Хот тохижилт	1,717.0	31.3	1,748.3
Биеийн тамир спортын газар	358.9	2.9	361.8
Соёлын байгууллага	1,754.7	87.4	1,842.1
Соёлын байгууллагуудын байр ашиглалтын зардал	756.4	18.0	774.4
ТЗШ-ын байгууллагуудын байр ашиглалтын зардал	5,405.2	(483.6)	4,921.6
Засаг дарга ерөнхий данс	2,316.5	347.0	2,663.5
Замын Үүд сумын ОНХО	36.9	-	36.9
НИЙТ ТЭНЦЭЛ	8,089.8	(409.4)	7,680.4

Үндсэн тэнцлийн ашгаас улсын төсөвт 124.1 сая төгрөгийг төвлөрүүлэх, орон нутгийн хөгжлийн санд 753.3 сая төгрөг, орон нутгийн хөрөнгө оруулалтад 6,803.0 сая төгрөгийг зарцуулахаар баталсан байна.

Орон нутгийн орлого, зарлагын өөрчлөлт.

1.3.2. Аймаг, сумдын ИТХ-ын тогтоолоор 2019 онд 2 удаа төсөвт нэмэлт өөрчлөлт хийж, орон нутгийн нийт орлогыг 32,567.4 сая төгрөг, орон нутгийн нийт зарлагыг 32,588.5 сая төгрөгөөр баталжээ.

Төсвийн нэмэлт өөрчлөлтөөр орон нутгийн суурь орлогод өөрчлөлт хийгээгүй, харин оны эхний үлдэгдлээс санхүүжих эх үүсвэрийг 876.9 сая төгрөгөөр, орон нутгийн суурь зардлыг 898.0 сая төгрөгөөр нэмэгдүүлж, төсвийн тэнцлийг 21.1 сая төгрөгийн алдагдалтай баталсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.2.2-т "Төсвийн захирагч нь жил бүрийн төсвийн зарлагыг орлого болон санхүүжүүлэх бусад эх үүсвэрээр нь бүрэн нөхдөг байхаар төлөвлөн баталж, хэрэгжүүлэх", 57.2-т "Орон нутгийн төсвийг алдагдалгүй төлөвлөн баталж, хэрэгжүүлнэ", 57.3-т "Орон нутгийн төсвийн урьд оны үлдэгдлээс санхүүжүүлэх зарлагыг төсөвт тусган баталж хэрэгжүүлэх ба зарлага нь санхүүжүүлэх эх үүсвэрээсээ хэтрэхгүй байна" гэж заасныг зөрчсөн байна.

Орон нутгийн төсөвт орсон нэмэлт өөрчлөлт

Хүснэгт №4

сая төгрөгөөр

Үзүүлэлт	Анхны Батлагдсан төсөв	Төсвийн нэмэлт өөрчлөлт	Нэмэлт өөрчлөлт орсон төсөв
Орон нутгийн төсвийн нийт орлого	31,690.5	876.9	32,567.4
Орон нутгийн суурь орлого	31,190.5	-	31,190.5
Татварын орлого	27,842.9	-	27,842.9
Татварын бус орлого	3,347.6	-	3,347.6
Урьд оны үлдэгдэл	500.0	876.9	1,376.9

Орон нутгийн төсвийн нийт зардал	31,690.5	898.0	32,588.5
<i>Орон нутгийн суурь зардал</i>	<i>30,813.1</i>	<i>898.0</i>	<i>31,711.1</i>
Аймаг сумдын ИТХ	1,833.1	69.3	1,902.4
Аймаг сумдын ЗДТГ	7,845.5	314.5	8,160.0
ЗАА	254.3	7.7	262.0
СХАА	158.0	5.9	163.9
ОНӨГ	139.6	9.1	148.7
БОАЖГ	404.7	-	404.7
Халамжийн сан	119.8	-	119.8
Хот тохижилт	1,717.0	31.3	1,748.3
Биеийн тамир спортын газар	358.9	2.9	361.8
Соёлын байгууллага	1,754.7	87.4	1,842.1
Соёлын байгууллагуудын байр ашиглалтын зардал	756.4	18.0	774.4
ТЗШ-ын байгууллагуудын байр ашиглалтын зардал	5,405.2	(483.6)	4,921.6
Засаг дарга ерөнхий данс	9,030.4	835.5	9,865.9
Замын Үүд сумын ОНХО	1,035.5	-	1,035.5
<i>Орон нутгийн орлогын шилжүүлэг</i>	<i>877.4</i>	<i>-</i>	<i>877.4</i>
УТ-т төвлөрүүлэх орлого	124.1	-	124.1
ОНХС-д олгох орлогын шилжүүлэг	753.3	-	753.3
НИЙТ ТЭНЦЭЛ	-	(21.1)	(21.1)

Төсвийн нэмэлт өөрчлөлтөөр удирдлагыг хэрэгжүүлэх зардлыг 406.5 сая төгрөгөөр, хот тохижилтын зардлыг 31.3 сая төгрөгөөр, биеийн тамир болон соёлын байгууллагын зардлыг 108.3 сая төгрөгөөр, ОНХО-ын зардлыг 835.5 сая төгрөгөөр тус тус нэмэгдүүлэн, ТЗШ-ын байгууллагын байр ашиглалтын зардлыг 483.6 сая төгрөгөөр бууруулсан байна.

1.3.3. Аймгийн ИТХ-ын 2018 оны 9/08 дугаар тогтоолоор сумын төсөвт олгох санхүүгийн дэмжлэгийг 5,329.5 сая төгрөгөөр баталж, 2019 оны төсвийн нэмэлт өөрчлөлтөөр нийт 263.1 сая төгрөгөөр нэмэгдүүлэн 5,592.6 сая төгрөгөөр баталсан байна.

Аймгийн төсвөөс сумын төсөвт олгох санхүүгийн дэмжлэг

Хүснэгт №5

сая төгрөгөөр

Д/д	Сумын нэр	Анхны Батлагдсан төсөв	2019 оны 11/09-р тогтоолоор	2020 оны 11/09-р тогтоолоор	Нэмэлт өөрчлөлт орсон төсөв
1	Айраг	360.1	15.5	7.2	382.8
2	Алтанширээ	368.4	14.2	2.8	385.4
3	Даланжаргалан	221.8	25.2	-	247.1
4	Дэлгэрэх	354.1	2.7	-	356.8
5	Иххэт	395.6	10.5	27.0	433.0
6	Мандах	367.0	12.5	-	379.5
7	Өргөн	394.7	16.8	1.7	413.2
8	Сайхандулаан	350.1	15.8	1.5	367.3
9	Улаанбадрах	350.8	46.9	-	397.6
10	Хатанбулаг	309.4	8.6	2.6	320.7
11	Хөвсгөл	379.7	9.0	5.1	393.8
12	Эрдэнэ	417.7	11.4	(27.0)	402.1
13	Сайншанд	1,060.2	53.1	-	1,113.3
Нийт дүн		5,329.5	242.2	20.9	5,592.6

АИТХ-ын 2019 оны 11/09 дүгээр тогтоолоор Алтанширээ, Сайншанд сумдад олгох дэмжлэгийн хэмжээг 67.3 сая төгрөгөөр нэмэгдүүлсэн байтал сумын ИТХ-аар төсөвт тодотгол хийж батлаагүй, санхүүжилтийг олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 64 дүгээр зүйлийн 64.1.2-т "Аймаг сумдын иргэдийн Төлөөлөгчдийн хурал нь тухайн жилийн төсөв, түүний тодотголын төслийг хэлэлцэн батлах, хэрэгжилтэд хяналт тавих, нийтэд мэдээлэх", 66 дугаар зүйлийн 66.1.1-т "Сум

дүүргийн Засаг дарга нь тухайн шатны төсвийн төсөл, түүний тодотголын төслийг боловсруулах, хэлэлцүүлэх, батлуулах, төсвийн гүйцэтгэлийг зохион байгуулж, тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд тайлагнана” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.


1.4 Аймгийн төсвийн нийт орлогыг 71,330.2 сая төгрөг, нийт зардлын төсвийг 71,351.3 сая төгрөгөөр баталсан байна.

Аймгийн нийт орлого.

1.4.1. Аймгийн 2019 оны нийт орлогыг 71,330.2 сая төгрөгөөр баталсны 29,464.9 сая төгрөгийг тусгай зориулалтын шилжүүлгээс, 6,795.9 сая төгрөгийг орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас, 31,190.5 сая төгрөгийг орон нутгийн татварын болон татварын бус орлогоос, 254.7 сая төгрөгийг ЭМД-ийн сангаас, 1,331.1 сая төгрөгийг СХС-ийн зээлийн эргэн төлөлт болон нөхөн сэргээлтийн тусгай дансны барьцаа хөрөнгөөс, 7.5 сая төгрөгийг ТЗШ-ийн байгууллагын үйл ажиллагааны орлогоос, 180.7 сая төгрөгийг орон нутгийн хөгжлийн санд төвлөрүүлэх бусад орлогоос, 1,376.9 сая төгрөгийг аймгийн төсвийн урьд оны үлдэгдлээс, 728.0 сая төгрөгийг ОНХС, СХС, нөхөн сэргээлтийн тусгай дансны оны эхний үлдэгдлээс тус тус санхүүжүүлэхээр төлөвлөсөн байна.

Аймгийн төсвийн эх үүсвэр

сая төгрөгөөр



1.4.2. ТЗШ-ийн байгууллагад улсын төсвөөс 29,464.9 сая төгрөгөөр олгохоор ТЕЗ-д эрхийг шилжүүлсэн байна. Үүний 4,173.6 сая төгрөг буюу 14.2 хувийг ЭМС-ын, 24,610.5 сая төгрөг буюу 82.0 хувийг БСШУС-ын, 680.8 сая төгрөг буюу 3.8 хувийг ХАХНХС-ын болон БХБС-ын төсвөөс санхүүжүүлэхээр баталсан байна.

Төсвийн нэмэлт өөрчлөлтөөр холбогдох яамдаас олгосон зөвшөөрлийн дагуу боловсролын салбарын хэмжээнд үүссэн төсвийн урсгал өрийг барагдуулах, тулгамдсан асуудлыг шийдвэрлэх, зорилгоор төсөвт зохицуулалт хийжээ.

ТЗШ-ийн батлагдсан төсөвт орсон өөрчлөлт

Хүснэгт №6

сая төгрөгөөр

Салбарын нэр	Батлагсан төсөв / АИТХ-ын 2018 оны 9/08-р тогтоолоор/	Нэмэлт өөрчлөлт / Аймгийн ИТХ-ын 2019 оны 11/09, 12/07-р тогтоол/	Өөрчлөлт
Эрүүл мэндийн сайд	4,173.6	4,173.6	-
Сумын эрүүл мэндийн төв	3,513.8	3,513.8	-
Өрхийн эрүүл мэндийн төв	659.8	659.8	-
БСШУСайд	24,610.5	24,610.5	-
Ерөнхий боловсролын сургууль	16,453.0	15,933.7	(519.30)
Хүүхдийн цэцэрлэг	8,157.5	8,676.8	519.30
ХАХНХСайд	293.3	293.3	-
ГБХЗХөгжлийн газар	293.3	293.3	-

БХБСайд	387.5	387.5	-
ГХБХБГазар	387.5	387.5	-
Нийт	29,464.9	29,464.9	-

1.4.3. ТЗШ-ийн байгууллагуудын төсөвт 2019 онд ашиглалтад орох сургуулийн төсөв 1,739.0 сая төгрөгийг тооцож батлуулсан байна. Тус сургууль нь 2019 оны 10 сард ашиглалтад орж 224.2 сая төгрөгийн санхүүжилт авч, хэмнэгдсэн төсөв 1,514.8 сая төгрөгийг БСШУС-ын харьяа байгууллагуудад хуваарилан, төсөвт зохицуулалт хийсэн байна. Тухайлбал, ЕБС-дад 995.5 сая төгрөг, хүүхдийн цэцэрлэгүүдэд 519.3 сая төгрөгийг тус тус хуваарилсан байна.

БСШУС-ын багцын батлагдсан төсөв, нэмэлт өөрчлөлт

Хүснэгт №7

сая төгрөгөөр

Д/д	Сумын нэр	ЕБСургууль			Цэцэрлэг		
		Бат/төсөв	Нэмэлт өөрчлөлт орсон төсөв	Зөрүү	Бат/төсөв	Нэмэлт өөрчлөлт орсон төсөв	Зөрүү
1	Айраг	811.5	774.8	(36.8)	279.5	284.9	5.3
2	Алтанширээ	310.5	362.3	51.8	116.0	152.8	36.8
3	Даланжаргалан	362.9	575.8	212.9	215.1	338.7	123.6
4	Дэлгэрэх	442.0	455.0	13.0	175.3	168.5	(6.8)
5	Иххэт	507.4	536.6	29.2	230.0	245.7	15.6
6	Мандах	369.6	418.0	48.4	118.8	146.2	27.3
7	Өргөн	406.7	393.1	(13.6)	196.0	180.1	(15.9)
8	Сайхандулаан	462.2	306.3	(155.9)	144.3	139.8	(4.5)
9	Улаанбадрах	373.5	413.1	39.6	131.0	157.4	26.4
10	Хатанбулаг	506.4	553.4	47.0	232.2	254.8	22.6
11	Хөвсгөл	429.4	468.7	39.3	150.3	183.0	32.7
12	Эрдэнэ	460.6	463.4	2.8	179.8	182.7	2.9
13	Сайншанд	7,325.1	6,253.5	(1,071.7)	3,788.5	4,100.1	311.6
14	Замын-Үүд	3,685.0	3,959.8	274.8	2,200.7	2,142.3	(58.4)
Нийт дүн		16,453.0	15,933.8	(519.3)	8,157.6	8,676.8	519.3

Сайншанд сумын ЕБС-дад 443.2 сая төгрөгийг, Замын Үүд сумын ЕБС-дад 274.8 сая төгрөгийг тус тус нэмж хуваарилсан байна.

Зардлын төсөвт орсон өөрчлөлтийг авч үзэхэд цалин, НДШ-ийн зардлыг 1,022.1 сая төгрөгөөр, нормативт зардлыг 200.2 сая төгрөгөөр бууруулан, хангамжийн материалын зардлыг 56.3 сая төгрөгөөр, эд хогшил худалдан авах зардлыг 685.2 сая төгрөгөөр нэмэгдүүлсэн байна.

1.4.4. Орон нутгийн хөгжлийн сангийн төсвийг 7,783.8 сая төгрөгөөр баталсан бөгөөд 6,795.9 сая төгрөгийг ОНХНС-ийн орлогын шилжүүлгээс, 753.3 сая төгрөгийг аймгийн орон нутгийн орлогоос, 180.7 сая төгрөгийг хандивын орлогоос, 53.9 сая төгрөгийг оны эхний үлдэгдлээс санхүүжүүлэхээр баталсан байна.

Аймгийн ИТХ-ын 2018 оны 9/08-р тогтоолоор ОНХНС-аас олгох санхүүжилтийн 2,660.4 сая төгрөгийг аймгийн ОНХС-д, 4,135.5 сая төгрөгийг сумдын ОНХС-д олгохоор хуваарилсан байна. Нийт батлагдсан төсвийн 4,189.0 сая төгрөг буюу 53.8 хувийг сумдын ОНХС, 3,594.8 сая төгрөг буюу 46.2 хувийг аймгийн ОНХС-ийн төсөв тус тус эзэлж байна.

Аймгийн нийт зарлага.

1.4.5. Аймгийн 2019 оны нийт зардлын төсвийг 70,453.3 сая төгрөгөөр баталж, төсвийн нэмэлт өөрчлөлтөөр сумдад олгох санхүүгийн дэмжлэгийг 263.1 сая төгрөгөөр, соёлын байгууллагын байр ашиглалтын зардлыг 18.0 сая төгрөгөөр, аймгийн төвийн төсвийн шууд захирагчийн байгууллагын зардлыг 1,100.5 сая төгрөгөөр тус тус нэмэгдүүлж, ТЗШ-ийн байгууллагын байр ашиглалтын зардлыг 483.6 сая төгрөгөөр бууруулж, нийт 71,351.3 сая төгрөгөөр баталсан байна.

Аймгийн батлагдсан төсөв, орсон нэмэлт өөрчлөлт

Хүснэгт №8

сая төгрөгөөр

№	Ангилал	Төсөв		Төсөвт орсон өөрчлөлт	ТГТ-ын батлагдсан төсөв	Зөрүү
		Батлагдсан	Тодотгосон			
1	Тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллага	35,132.4	34,648.8	(483.6)	34,648.8	-
2	Орон нутгийн төсвийн байгууллага	25,407.9	26,789.5	1,381.6	26,786.5	(3.0)
3	Орон нутгийн хөгжлийн сан	7,783.8	7,783.8	-	7,783.8	-
4	Сум хөгжүүлэх сан	1,737.4	1,737.4	-	1,737.4	-
5	Нөхөн сэргээлтийн сан	267.6	267.6	-	267.6	-
6	Улсын төсөвт төвлөрүүлэх орлого	124.1	124.1	-	124.1	-
Дүн		70,453.3	71,351.3	898.0	71,348.3	(3.0)

Нийт батлагдсан төсвийн 48.6 хувийг ТЗШ-ийн байгууллагын, 37.5 хувийг орон нутгийн төсвийн байгууллагын үйл ажиллагааны зардлыг санхүүжүүлэхэд, 10.9 хувийг ОНХС, 2.8 хувийг СХС болон нөхөн сэргээх тусгай дансны зардлыг санхүүжүүлэхэд зарцуулахаар, 0.2 хувийг улсын төсөвт төвлөрүүлэхээр төлөвлөсөн байна.

1.4.6. Сайншанд сумын соёлын төвд батлагдсан төсвийн зарцуулах эрхийг 3.0 сая төгрөгөөр дутуу олгосноос, ТЭЗ-ийн 2019 оны ТГТ-ийн батлагдсан төсвийг 71,348.3 сая төгрөгөөр тайлагнасан байна. Мөн Айраг, Эрдэнэ сумдын ЕБС-ийн төсвийг 80.0 мянган төгрөгөөр зөрүүтэй тусган, төсвийг баталгаажуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1.8-т “Төрийн сан нь төсвийн сар, улирлын хуваарьт үндэслэн төсвийн байгууллагын бүртгэлийн дансанд санхүүжилтийн болон зарцуулалтын эрх олгох”, Засгийн газрын 2015 оны 24-р тогтоолоор батлагдсан Төрийн сангийн үйл ажиллагааны журмын 8 дугаар зүйлийн 8.1-д “Төрийн сан нь Төсвийн тухай хуулийн 37, 38 дугаар зүйлд заасны дагуу ... батлагдсан төсвийн хуваарийн дагуу бүртгэж, төлбөр тооцоог гүйцэтгэнэ” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

1.4.7. Аймгийн ИТХ-ын 2018 оны 9/08 дугаар тогтоолоор аймгийн 2019 оны хөрөнгө оруулалтын төсвийг 7,717.9 сая төгрөгөөр, замын сангийн хөрөнгө оруулалтыг 669.0 сая төгрөгөөр, Замын- Үүд сумын ИТХ-ын 2018 оны 10/09 дүгээр тогтоолоор сумын хөрөнгө оруулалтын төсвийг 1,035.5 сая төгрөгөөр баталж, төсвийн нэмэлт өөрчлөлтөөр аймгийн хөрөнгө оруулалтын төсвийг 672.5 сая төгрөгөөр нэмэгдүүлж нийт зардлыг 10,094.9 сая төгрөгөөр баталсан байна.

Хөрөнгө оруулалтад 704.4 сая төгрөгийг аймгийн төсвийн оны эхний үлдэгдлээс, 41.9 сая төгрөгийг автозамын сангийн орлогоос, 9,348.6 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр баталсан байна.

Хөрөнгө оруулалтын төсвийг батлахдаа Төсвийн тухай хуулийн 4.1.24-т "хөрөнгө оруулалт: гэж төсвөөс санхүүжүүлж, тухайн шатны төсөвт хамаарах хуулийн

этгээдийн өмчлөлд шилжих хөрөнгийн зарлагыг” хэлнэ гэж заасныг зөрчиж хөрөнгө оруулалтын бус зардалд аймаг 75.0 сая төгрөгийн төсөв баталсан байна. Үүнд:

- Хатанбулаг сумын 100 жилийн ойд зориулсан теле бичлэг хийх ажил 15.0 сая төгрөг,
- Эрдэнэ сумын түүхийг харуулсан зурагт альбом хийх ажил 10.0 сая төгрөг,
- Зүүнбаян Нефтийн үйлдвэрийн 70 жилийн ойд зориулсан зурагт сэтгүүл хэвлүүлэх ажил 10.0 сая төгрөг,
- Дорноговь аймгийн түүхэн баримтат кино хийх ажил 40.0 сая төгрөг

1.4.8. Орон нутагт үйл ажиллагаа явуулж байгаа тусгай зориулалтын шилжүүлгээр санхүүждэг байгууллагуудын байр ашиглалтын зардлыг 5,405.1 сая төгрөгөөр баталж, нэмэлт өөрчлөлтөөр 483.6 сая төгрөгөөр хасаж, 4,921.5 сая төгрөг байхаар баталсан байгаа нь Сангийн яамнаас хянасан төсвийг 636.8 сая төгрөгөөр бууруулсан байна.

ТЗШ-ийн байгууллагын байр ашиглалтын зардлын төсөв

Хүснэгт №9

сая төгрөгөөр

№	ТЗШ-ийн байгууллага	СЯ-ны хянасан	Анх Бат/төсөв-	Нэмэлт өөрчлөлт орсон төсөв	СЯ-ын хянасан, АИТХ-ын баталсан зөрүү	Нэмэлт өөрчлөлт-Зөрүү
1	ЕБСургууль	3,773.8	3,620.6	3,275.6	(498.2)	(345.0)
2	Цэцэрлэг	1,526.7	1,526.7	1,339.6	(187.1)	(187.1)
3	ЭМТөв	204.0	204.0	252.5	48.5	48.5
4	ГХБХБГ	15.0	15.0	15.0	0.0	0.0
5	ГБХЗХГ	38.8	38.8	38.8	0.0	0.0
	Нийт	5,558.3	5,405.1	4,921.5	(636.8)	(483.6)

Нийт батлагдсан төсвийн 66.6 хувийг ЕБС, 27.2 хувийг цэцэрлэг, 5.1 хувийг ЭМТ, 1.1 хувийг ГХБХБГ болон ГБХЗХГ-т хуваарилахаар төсөвлөсөн байна.

Тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагын байр ашиглалттай холбоотой зардлыг төсвийн нэмэлт өөрчлөлтөөр 483.6 сая төгрөгөөр бууруулсан хэдий ч тайлант оны эцэст зарцуулагдаагүй үлдэгдэл 331.0 сая төгрөгийг орон нутагт буцаан төвлөрүүлсэн байна. Энэ нь тухайн зардлыг тооцоо судалгаанд үндэслэлгүй төлөвлөсөнтэй холбоотой байна.

БҮЛЭГ 2: ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ОРЛОГО НИЙТ ДҮНГЭЭРЭЭ 1,479.5 САЯ ТӨГРӨГӨӨР ДАВЖ, ТӨСВИЙН ЗАРЛАГЫН ГҮЙЦЭТГЭЛ 68.0 ТЭРБУМ ТӨГРӨГ БАЙНА.

2.1 Татварын болон татварын бус орлогыг бүрдүүлэх нөөц боломжийг бүрэн ашигласан байна.

2.1.1.Орон нутгийн төсвийн суурь орлогыг 31,190.5 сая төгрөгөөр төлөвлөж, гүйцэтгэлээр 32,725.7 сая төгрөгийн орлого төвлөрч, орлогын төлөвлөгөө 1,535.2 сая төгрөг буюу 4.9 хувиар давж биелсэн байна. Татварын орлого 11.1 хувиар давж, татварын бус орлого 8.4 хувиар тасарсан байна.

Орон нутгийн орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл

Хүснэгт №10

сая төгрөгөөр

Орлогын нэр төрөл	Нийт баталсан төсвийн орлого	Нийт гүйцэтгэл	Зөрүү	хувь
ТАТВАРЫН ОРЛОГО	21,342.9	23,706.9	2,364.0	111.1
1.Орлогын албан татвар	14,957.3	17,312.5	2,355.2	115.7
1.1.Хүн амын орлогын албан татвар	15,817.3	18,172.5	2,355.2	114.9
1.1.1. Цалин хөлс түүнтэй адилтгах бусад орлого	12,100.0	14,111.2	2,011.2	116.6
1.1.2. Үйл ажиллагааны орлогын татвар	2,065.0	2,227.9	162.9	107.9
1.1.4. Хөрөнгийн орлого	1,025.7	65.1	(960.5)	6.3
1.1.5. Хөрөнгө борлуулсны татвар	221.4	31.1	(190.3)	14.0
1.1.6. Шууд бус орлогын татвар	405.2	1,737.1	1,331.9	428.7
1.1.7. Хувь хүний орлогын албан татварын буцаалт	(860.0)	(860.0)	0.0	100.0
2.ӨМЧИЙН АЛБАН ТАТВАР	1,426.5	1,559.9	133.4	109.3
2.1. Үл хөдлөх хөрөнгийн албан татвар	685.2	908.3	223.1	132.6
2.2. Бууны албан татвар	31.3	28.7	(2.6)	91.6
2.3. АТБӨЯХ-ийн албан татвар	710.0	622.9	(87.1)	87.7
4. БУСАД ТАТВАР	4,959.1	4,834.5	(124.5)	97.5
4.1. Улсын тэмдэгтийн хураамж	1,827.5	2,444.7	617.2	133.8
4.2. Ан агнах зөвшөөрлийн хураамж	134.8	178.9	44.2	132.8
4.4. Газрын төлбөр	480.0	971.0	491.0	202.3
4.6. Рашаан, ус ашигласны төлбөр	251.2	357.9	106.7	142.5
4.7. Хог хаягдлын хураамж	381.0	295.7	(85.3)	77.6
4.9.Түгээмэл тархацтай ашигт малтмал	354.7	276.9	(77.8)	78.1
4.10. Бусад төлбөр хураамж	1,530.0	309.4	(1,220.6)	20.2
ТАТВАРЫН БУС ОРЛОГО	9,847.7	9,018.8	(828.8)	91.6
1. Түрээсийн орлого	27.0	58.9	31.9	218.3
2. Хүү торгуулийн орлого	2,124.0	3,391.0	1,266.9	159.6
3. Татварын бус бусад орлого	1,166.6	1,509.9	343.3	129.4
3.1. Нэр зааж ангилагдаагүй орлого	1,071.8	1,359.4	287.6	126.8
3.1 Төсөвт байгууллагын өөрийн орлого	94.9	150.6	55.7	158.7
4. ХӨРӨНГИЙН ОРЛОГО	6,530.0	4,059.0	(2,471.0)	62.2
4.1. Үндсэн хөрөнгө борлуулсны орлого	30.0	9.4	(20.6)	31.3
4.2. Дуудлага худалдааны орлого	6,500.0	4,049.7	(2,450.3)	62.3
Орон нутгийн төсвийн суурь орлого	31,190.6	32,725.7	1,535.2	104.9

2.1.2. Аймгийн төсөвт төвлөрөх зарим орлого давж биелэхэд дараах хүчин зүйл нөлөөлсөн байна. Үүнд:

- *Цалин хөлс, шагнал урамшуулал болон тэдгээртэй адилтгах орлого* 2,011.2 сая төгрөгөөр давсан нь төмөр замын ажилчдын цалин 10 хувиар нэмэгдсэнээс 560.2 сая төгрөгөөр, төсөвт байгууллагын цалин 8 хувиар нэмэгдсэнээр 350.1 сая төгрөгөөр, татвар төлөгчийн тоо 217-оор нэмэгдсэнээр 85.0 сая төгрөгөөр, өөр аймаг дүүргээс шилжин ирсэн 15 ААНБ-аас 93.4 сая төгрөгөөр, Бээжин интоксикэйшн интернэйшнл трейд /Замын-Үүд сум мал нядалгаа/ 65.5 сая төгрөгөөр, аймагт бүртгэлгүй уул уурхайн компаниудын татварын орлого аймагт төвлөрүүлсэнтэй холбоотой байна. Энэ нь өмнөх онтой харьцуулахад 15.6 хувиар өссөн үзүүлэлттэй байна.
- *Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар* 223.1 сая төгрөгөөр буюу 32.5 хувиар давж биелсэн нь аймгийн хэмжээнд нийт 142 үл хөдлөх хөрөнгө шинээр бүртгэгдсэн, уул уурхайн чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа 5 ААНБ-т 22 үл хөдлөх хөрөнгө нэмж шинээр бүртгэгдсэнтэй холбоотой байна.
- *Усны төлбөр* 106.7 сая төгрөгөөр буюу 42.7 хувиар давж биелсэн нь нүүрсний баяжуулах үйлдвэрүүдийн үйл ажиллагаа өргөжиж 40.2 сая төгрөгийн төлбөр нэмж ногдуулсан, Си Өү Эй Эл ХХК-д 77.5 сая төгрөгийн төлбөр нөхөн ногдуулснаас шалтгаалжээ.

Аймгийн төсөвт төвлөрөх зарим орлого тасарсан нь дараах шалтгаантай байна. Үүнд:

- *АТБӨЯХАТатвар* 87.1 сая төгрөгөөр буюу 12.3 хувиар тасарсан нь 127 авто тээврийн хэрэгслийн шилжилт хөдөлгөөнтэй холбоотой хасагдсан, өөр аймгийн дугаартай 350 тээврийн хэрэгслийн татвар аймагт төвлөрсөн боловч дугаарын харьяаллаар аймгийн орлогоос татагдсан, АТБӨЯХ-ийн бүртгэл давхардсан, бүртгэлд байгаа боловч эзэмшигч нь нас барсан, хөдөлгөөнд оролцох боломжгүй эвдэрсэн.
- *Бусад татварын орлого* 1,530.0 сая төгрөг төлөвлөснөөс 1,220.6 сая төгрөгөөр тасарсан байна. Энэ нь нүүрс тээвэрт явж байгаа ачаа тээврийн автомашинаас тээвэрлэлт хийх бүрд авахаар тооцоолсон боловч хуулийн этгээдэд бүртгэлтэй тээврийн хэрэгсэлд тухайн хураамжийг ногдуулах боломжгүй, дараа тайлангаарх ногдлоор ААНОАТ-т орох болсон тул тасарсан байна.

2.1.3. Татварын бус орлого 828.8 сая төгрөгөөр тасарсан нь дараах шалтгаантай байна. Үүнд:

- *Хөрөнгө борлуулсны орлого* 20.6 сая төгрөг буюу 68.8 хувиар тасарсан нь аймгийн хэмжээнд иргэдийн хөгжлийн барилга баригдаж, 2 дугаар багийн өрхийн эмнэлгийн барилгыг худалдахаар төлөвлөсөн байсан боловч иргэдийг хамгаалах төвийн зориулалтаар ашиглахаар шийдвэрлэсэн байна.
- *Дуудлага худалдааны орлого* 2,450.3 сая төгрөгөөр буюу 37.7 хувиар тасарсан байна. Аймгийн хэмжээний 12 суманд нийт 155 удаа дуудлага худалдаа зохион байгуулсан байна. Үүнээс 78 удаагийн дуудлага худалдаанд оролцогч ирээгүй, эрх бүхий албан тушаалтны шийдвэрээр цуцлагдсан зэрэг шалтгаанаар хүчингүй болсон байна.

2.1.4. Сумдын ИТХ-ын тогтоолоор сумдын орлогыг 9,143.4 сая төгрөгөөр баталж, орлогын гүйцэтгэл 10,116.9 сая төгрөг буюу 10.7 хувиар давж биелсэн байна.

Сумдын орон нутгийн орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл

Хүснэгт №11

сая төгрөгөөр

№	Сумдын нэр	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	давсан +/- тасарсан -/-	Хувь
1	Айраг	50.9	90.9	40.0	178.6
2	Алтанширээ	22.3	35.1	12.8	157.4
3	Даланжаргалан	222.8	321.2	98.4	144.2
4	Дэлгэрэх	42.9	57.2	14.3	133.3
5	Иххэт	30.4	52.0	21.6	171.1
6	Мандах	54.4	84.3	29.9	154.9
7	Сайхандулаан	20.4	30.8	10.4	150.9
8	Өргөн	62.0	113.7	51.7	183.3
9	Улаанбадрах	30.5	40.4	9.9	132.5
10	Хөвсгөл	39.7	55.3	15.6	139.3
11	Хатанбулаг	246.7	267.6	20.9	108.5
12	Эрдэнэ	104.9	150.6	45.7	143.6
13	Сайншанд	1,525.7	1,715.5	189.8	112.4
14	Замын-Үүд	6,689.8	7,102.3	412.5	106.2
Нийт		9,143.4	10,116.9	973.5	110.7

Сумдын төсвөөс давсан орлого болох 973.5 сая төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлж, 10.0 сая төгрөг нь Сайншанд сумын орон нутгийн ерөнхий орлогын дансанд үлдсэн байна. Тайлант онд төсөвт байгууллагуудын батлагдсан төсвөөс 2.3 сая төгрөгийн санхүүжилтийг дутуу олгосон байна.

2.1.5. Сумдын төсөвт төвлөрөх татварын болон татварын бус орлого нийт дүнгээрээ биелсэн боловч, дараах орлогууд тасарсан байна. Үүнд:

- *Галт зэвсгийн албан татвар* 2.6 сая төгрөгөөр буюу 8.7 хувиар тасарсан нь галт зэвсгийн ногдуулалтыг цагдаагийн бүртгэлээр ногдуулсантай холбоотой байна. Гэвч буу нь алга болсон, эвдэрсэн, цагдаад хураалгасан, эзэмшигч нь нас барсан зэргээс шалтгаалж тус татвар төлөгддөггүй байна.
- *Түгээмэл тархацтай ашигт малтмалын татвар* 77.7 сая төгрөгөөр буюу 22 хувиар тасарсан байна. Аймгийн хэмжээнд түгээмэл тархацтай ашигт малтмал ашиглах лицензтэй 4 ААНБ байдаг бөгөөд эдгээр байгууллагын түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласан хэмжээ, ногдуулсан татвар төлөвлөсөн хэмжээнд хүрээгүй байна.
- Тайлант онд *сумын хүн амын орлогын татварын төрөл болох хөрөнгийн орлого, хөрөнгө борлуулсны орлого* нэр төрлөөрөө тасарсан харагдаж байгаа боловч 2019 онд татвар удирдлагын нэгдсэн системд шилжиж тухайн төрлийн татварын нэр төрлөөрөө нэхэмжлэх үүсэхгүй болсон тул хувь хүний үйл ажиллагааны шууд бус орлогын албан татвар төрлөөр орлогод ордог болсонтой холбоотой.
- *Хог хаягдлын үйлчилгээний хураамж* 85.3 сая төгрөг буюу 23.4 хувиар тасарсан байна. Хог хаягдлын үйлчилгээний хураамжийн 70 хувь буюу 266.3 сая төгрөгийг Сайншанд болон Замын-үүд сумаас төвлөрүүлэхээр төлөвлөсөн байна. Гэтэл эдгээр сумдын хураамжийн орлого 84.3 сая төгрөгөөр тасарсан нь нийт тасарсан орлогын 98.8 хувийг эзэлж байна. Энэ нь багийн өрхийн бүртгэлд үндэслэн төлөвлөсөнтэй холбоотой байна. Мөн Сайншанд болон Замын-Үүд сумдын хог хаягдлын хураамжийг цахилгааны төлбөртэй хамт авдаг болсноор хог хаягдлын үйлчилгээний хураамж төлөх боломжтой бүх өрхүүд төлсөн байна. Хог хаягдлын тухай хуулийн 4.1.31 “хог хаягдлын үйлчилгээний хураамж” гэж хог хаягдлыг цуглуулж тээвэрлэх, булшлахад шаардагдах зардлын хувь хэмжээг харгалзан тогтоосон татвар”-ыг хэлнэ

гэж заасан байна. Иймээс хаяг дээрээ амьдардаггүй, хог хаягдал гаргахгүй байгаа өрх хураамж төлөх үндэслэлгүй болж байна.

2.1.6. Төсөвт байгууллагуудын өөрийн орлогыг бүрэн төлөвлөснөөр орон нутгаас олгох санхүүжилтийн хэмжээг бууруулах боломжтой байна.

Орон нутгийн төсөвт байгууллагуудын өөрийн орлогыг 94.9 сая төгрөгөөр баталж, гүйцэтгэлээр 150.6 сая төгрөг төвлөрч, 55.7 сая төгрөгөөр давж биелсэн байна.

Өөрийн орлогын давж биелсэн нь дараах дараах хүчин зүйлтэй холбоотой байна.
Үүнд:

- Сумдын орон нутгийн соёлын байгууллагуудаас 6.5 сая төгрөгийн өөрийн орлогыг төвлөрүүлсэн боловч орлогыг төлөвлөөгүй;
- Саранхөхөө театр 2.2 сая төгрөгийн өөрийн орлогыг төвлөрүүлсэн боловч төлөвлөөгүй;
- Аймгийн номын сан, Музей сургалт судалгааны төвийн 0.2 сая төгрөгийн өөрийн орлогыг төвлөрүүлсэн боловч огт төлөвлөөгүй байна.
- Замын сангийн орлогын төлөвлөгөөг 41.9 сая төгрөгөөр төлөвлөж гүйцэтгэлээр 55.2 сая төгрөг төвлөрсөн байна.
- Биеийн тамир спортын газрын өөрийн орлогыг 10.0 сая төгрөгөөр төлөвлөж гүйцэтгэлээр 13.4 сая төгрөг төвлөрсөн байна.

Дээрх нөхцөл байдлаас харахад төсөвт байгууллагын өөрийн орлогыг зөв төлөвлөж, төсвийн эх үүсвэрийг бүрдүүлснээр орон нутгаас олгох санхүүжилтийн хэмжээг бууруулах боломжтой байна. Цаашид төсөвт байгууллагын үйл ажиллагааны орлогыг үндэслэлтэй төлөвлөж, батлуулах шаардлагатай байна.

2.2. Орон нутгийн төсвийн зардлын гүйцэтгэл 22,882.7 сая төгрөг байна.

2.2.1. Орон нутгийн төсвийн суурь зардлыг 23,510.1 сая төгрөгөөр баталж, гүйцэтгэлээр 22,882.7 сая төгрөгийн зарцуулж, зардлын хэмнэлт болох 627.4 сая төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн байна.

Орон нутгийн суурь зардлын төлөвлөгөө, гүйцэтгэл

Хүснэгт №12

сая төгрөгөөр

№	Байгууллагын нэр	Батлагдсан төсөв	Гүйцэтгэл	Зөрүү
1	Аймаг сумдын ИТХ	1,902.4	1,866.4	36.0
2	Аймаг сумдын ЗДТГ	8,160.0	8,046.9	113.1
3	ЗАА	262.0	257.9	4.2
4	СХАА	163.9	163.0	0.9
5	ОНӨГ	148.7	147.2	1.4
6	БОАЖГ	404.7	402.2	2.5
7	Халамжийн сан	119.8	115.8	4.0
8	Хот тохижилт	1,748.2	1,742.2	6.1
9	Биеийн тамир спортын газар	361.8	361.0	0.8
10	Соёлын байгууллага	1,842.1	1,824.6	17.5
11	Соёлын байгууллагуудын байр ашиглалтын зардал	774.4	758.5	15.9
12	ТЗШ-ын байгууллагуудын байр ашиглалтын зардал	4,921.6	4,590.6	331.0
13	Засаг дарга ерөнхий данс	2,663.5	2,571.1	92.3
14	Замын Үүд сумын ОНХО	36.9	35.5	1.4
Дүн		23,510.1	22,882.7	627.4

ЗДТГ-ын зардлын хэмнэлтийг авч үзэхэд аймгийн ЗДТГ, Замын-Үүд, Сайншанд сумдын ЗДТГ-ын хэмнэлт нийт 86.9 сая төгрөг байгаа бөгөөд цалин, НДШ-ийн зардал 27.8 сая төгрөгөөр, тогтмол зардлын хэмнэлт 30.8 сая төгрөгөөр, томилолтын зардал 9.4 сая төгрөгөөр, бусад зардал 18.9 сая төгрөгөөр тус тус хэмнэгдсэн байна.

Засаг даргын ерөнхий дансны хэмнэлтэд дараах зардлын хэмнэлт нөлөөлсөн байна. Тухайлбал, нийтийн тээврийн нөхөн олговор 18.8 сая төгрөг, замын сангийн 8 ТАХ-ний зардлын хэмнэлт 13.8 сая төгрөг, хөрөнгийн зардлын 6 ТАХ-ээс 9.3 сая төгрөг, ажил олгогчоос олгох тэтгэмж урамшуулалтын зардал 58.5 сая төгрөг байна.

Тусгай зориулалтын шилжүүлгээр санхүүждэг байгууллагын байр ашиглалтын зардлын төсөвт гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 4,921.6 санхүүжилтийг олгож, тогтмол болон урсгал засварын зардалд 4,590.6 сая төгрөгийг зарцуулан, 331.0 сая төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн байна.

Төсвийн гүйцэтгэлийн тайланд Замын сангийн хөрөнгийн батлагдсан төсөв, гүйцэтгэлийг урсгал үйл ажиллагааны зардлын төсөвт батлан тайлагнасан байна.

Замын сангийн 13 төсөл арга хэмжээнд нийт 669.0 сая төгрөг зарцуулахаас гүйцэтгэлээр 648.3 сая төгрөгийг зарцуулсан байна. Нийт гарсан зардлын 292.2 сая төгрөг нь өмнө оны 4 төсөл арга хэмжээний үлдэгдэлд, 356.1 сая төгрөгийг тайлант онд шинээр хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээнд тус тус зарцуулсан байна.

2.3. Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас 1,251.8 сая төгрөгийн орлогын шилжүүлгийг дутуу олгожээ.

2.3.1. Аймгийн 2019 оны нийт зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 71,330.2 сая төгрөгөөр баталж, гүйцэтгэлээр 67,881.4 сая төгрөгийг санхүүжүүлэн, 95.1 хувийн биелэлттэй байна.

Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийн төлөвлөгөө, гүйцэтгэл

Хүснэгт №13

сая төгрөгөөр

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр	71,330.2	67,881.4	3,448.8	95.1
Улсын төсвөөс санхүүжих	36,260.8	34,744.2	1,516.6	95.8
Орон нутгийн төсвөөс санхүүжих	31,095.7	31,578.9	(483.2)	101.6
Эрүүл мэндийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	254.7	183.3	71.4	72.0
Төсөвт байгууллагын үйл ажиллагааны орлого болон сангийн орлого /СХСан, НС тусгай дансны барьцаа хөрөнгө, төсөвт байгууллагын өөрийн орлого/	1,614.2	1,374.9	239.3	85.2
Оны эхний үлдэгдлээс санхүүжих	2,104.8	-	2,104.8	-

Нийт эх үүсвэрийн 51.2 хувийг улсын төсвийн санхүүжилт, 46.5 хувийг орон нутгийн төсвийн санхүүжилт, 0.3 хувийг ЭМДС-ийн санхүүжилт, 2.0 хувийг төсөвт байгууллагын өөрийн орлого болон тусгай сангийн орлого тус тус эзэлж байна.

2.3.2. Замын-Үүд сумын төсвөөс аймгийн төсөвт 3,933.3 сая төгрөгийг татан төвлөрүүлэхээр төлөвлөж, бүрэн төвлөрүүлсэн байна.

2.3.3. Улсын төсвөөс тусгай зориулалтын шилжүүлэг 29,464.9 сая төгрөгийг 100 хувь олгож, ЕБС-ийн санхүүжилтэд 15,933.8 сая төгрөгийг, цэцэрлэгийн санхүүжилтэд 8,676.8

сая төгрөгийг, ЭМТ-ийн санхүүжилтэд 4,173.6 сая төгрөгийг, ГХБХБГ болон ГБХЗХГ-ын санхүүжилтэд 680.8 сая төгрөгийг хуваарилсан байна.

2.3.4. Аймаг сумдын ИТХ-ын тогтоолоор ОНХС-ийн 2019 оны төсвийг 7,783.8 сая төгрөгөөр баталж, гүйцэтгэлээр 6,510.9 сая төгрөгийн санхүүжилтийг олгожээ.

Аймгийн ОНХС-ийн орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл

Хүснэгт №14

сая төгрөгөөр

№	Эх үүсвэр	Орлого		Зөрүү
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	
1	ОНХНС-аас олгох	6,795.9	4,782.1	(2,013.8)
2	Тогтвортой амьжиргаа төслөөс санхүүжих	-	762.0	762.0
3	Бусад орлого /хандив/	180.7	159.6	(21.1)
4	Орон нутгийн төсвийн орлогоос санхүүжих	753.3	753.3	-
5	Оны эхний үлдэгдлээс	53.9	53.9	-
Дүн		7,783.8	6,510.9	(1,272.9)

Монгол Улсын 2019 оны Төсвийн тухай хуулиар ОНХНС-аас аймгийн ОНХС-д олгох орлогын шилжүүлгийг 6,795.9 сая төгрөгийг баталж, гүйцэтгэлээр 4,782.1 сая төгрөгийн санхүүжилтийг олгож, 2,013.8 сая төгрөгийн санхүүжилтийг дутуу олгосон байна. Энэ нь улсын хэмжээнд зарим уул уурхайн лицензийг цуцалсан, уул уурхайн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл бүхий ААНБ-ууд төлбөрөө хугацаанд нь төлж барагдуулаагүйгээс /мэдээллийн эх үүсвэр¹/ санхүүжилтийг дутуу олгосон байна.

Дутуу олгосон санхүүжилтийн зарим хэсгийг Тогтвортой амьжиргаа-3 төслийн санхүүгийн дэмжлэгээс бүрдүүлсэн байна. Бусад орлогоос 180.7 сая төгрөгийг төлөвлөж, “SMART OIL MONGOLIA LLC”-аас 159.9 сая төгрөгийн хандив шилжүүлж, орлого 21.1 сая төгрөгөөр тасарсан байна.

Төсвийн тухай хуульд ОНХС-ийн эх үүсвэрийг гадаад, дотоодын хандив тусламжаас бүрдүүлэхээр заасан ч Хатанбулаг сум 62.5 сая төгрөг, Хөвсгөл сум 55.0 сая төгрөг, Айраг сум 31.0 сая төгрөг, Даланжаргалан сум 15.0 сая төгрөг, нийт 163.5 сая төгрөгийн хандивыг уул уурхайн компаниудаас авч нэмэлт санхүүжилтийн дансанд төвлөрүүлж Хатанбулаг, Хөвсгөл сумд зарцуулсан байна. Харин Айраг сум хандивын орлогыг зарцуулаагүй байсан тул ОНХС-д төвлөрүүлэхээр төлбөрийн акт тогтоолоо.

Хандив тусламжийн орлогыг аймгийн ОНХС-д төвлөрүүлснээр орлогын эх үүсвэрийг нэмэгдүүлж, тайлант онд үүссэн өглөгийг бууруулах боломжтой байв.

2.3.5. Сумдын ИТХ-ын тогтоолоор сум хөгжүүлэх сангийн дансанд төвлөрүүлэх хөрөнгийг 1,172.5 сая төгрөг, нөхөн сэргээлтийн тусгай дансанд төвлөрүүлэх барьцаа хөрөнгийг 158.5 сая төгрөгөөр тус тус төлөвлөж, гүйцэтгэлээр сум хөгжүүлэх сангийн зээлийн эргэн төлөлт болон хүүгийн орлого 1,018.2 сая төгрөг, нөхөн сэргээлтийн тусгай дансны барьцаа хөрөнгө 65.5 сая төгрөг төвлөрсөн байна.

Сум хөгжүүлэх сангийн орлого 154.3 сая төгрөгөөр, нөхөн сэргээлтийн тусгай дансны орлого 93.0 сая төгрөгөөр тус тус тасарсан нь сангуудын орлогын төлөвлөлтийг тодорхой тооцоо судалгаанд үндэслэн хийгээгүй, СХС-ийн тайлант онд төвлөрөх зээлийн эргэн

¹ Монгол Улсын Сангийн сайдын 2020 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн 4-1/384 дугаар чиглэл өгөх тухай албан бичиг.

төлөлт бүрэн төвлөрөөгүй, ШШГГ-д байгаа зээлийн барагдуулалт хангалтгүй зэрэг шалтгаантай байна.

Сум хөгжүүлэх болон нөхөн сэргээлтийн сангийн орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл

Хүснэгт №15

сая төгрөгөөр

Үзүүлэлт	Батлагдсан төсөв			Орлогын гүйцэтгэлээс	Зөрүү
	Оны эхний үлдэгдлээс	Тайлант оны орлогоос	Нийт		
Сум хөгжүүлэх сан	564.9	1,172.5	1,737.4	1,018.2	154.3
Нөхөн сэргээлтийн сан	109.0	158.5	267.5	65.5	93.0
Нийт	673.9	1,331.0	2,004.9	1,083.7	247.3

Аймгийн нийт зарлагын гүйцэтгэл.

2.3.6. Аймгийн ТЕЗ-ын 2019 оны төсвийн гүйцэтгэлийн тайлангаар 71,348.3 сая төгрөгийн зардлын төсөв батлагдаж, гүйцэтгэлээр 68,042.7 сая төгрөгийг зарцуулсан байна. /95.4 хувийн гүйцэтгэлтэй/.

Энэ нь өмнөх оны гүйцэтгэлээс 1.7 хувиар буурсан бөгөөд төсвийн нийт зарлагын 49.9 хувийг тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллага, 38.8 хувийг орон нутгийн төсөвт байгууллага, 11.3 хувийг тусгай сангийн зардал эзэлж байна.

Зардлын төлөвлөгөө, гүйцэтгэл

Хүснэгт №16

сая төгрөгөөр

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	71,348.3	68,042.7	3,305.5	95.4
Урсгал зардал	54,277.0	52,466.0	1,811.1	96.7
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	29,404.4	29,163.3	241.2	99.2
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	3,730.8	3,675.9	54.9	98.5
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	6,181.4	5,811.7	369.7	94.0
Хангамж, бараа материалын зардал	1,630.4	1,570.1	60.3	96.3
Нормативт зардал	2,057.7	2,022.7	35.0	98.3
Эд хогшил, урсгал засварын зардал	1,755.4	1,742.0	13.4	99.2
Томилолт, зочны зардал	335.4	315.8	19.6	94.2
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4,904.1	4,330.7	573.4	88.3
Бараа үйлчилгээний бусад зардал	2,674.4	2,313.9	360.5	86.5
Хувийн хэвшлийн байгууллагад олгох санхүүгийн дэмжлэг	512.6	512.6	-	100.0
Засгийн газрын урсгал шилжүүлэг	124.1	124.1	-	100.0
Бусад урсгал шилжүүлэг	966.3	883.2	83.2	91.4
Хөрөнгийн зардал	17,071.3	15,576.8	1,494.5	91.2

Төсвийн нийт зардлын 77 хувийг урсгал зардалд, 23 хувийг хөрөнгийн зардалд зарцуулсан байна.

2.3.7. Нийт зардлын 48.2 хувь буюу 32,839.2 сая төгрөг нь цалин, ажил олгогчоос төлөх НДШ-ийн зардал, 18,106.9 сая төгрөг буюу 26.6 хувийг бараа үйлчилгээний бусад зардал, 636.7 сая төгрөг буюу 0.9 хувийг улсын төсөвт төвлөрүүлсэн болон хувийн хэвшлийн байгууллагад олгосон татаас шилжүүлэг, 883.2 сая төгрөг буюу 1.3 хувийг бусад

урсгал шилжүүлэг , 15,576.8 сая төгрөг буюу 22.9 хувийг хөрөнгийн зардал тус тус эзэлж байна.

2.3.8.Тайлант онд төсвийн гүйцэтгэлийн тайлангаар нийт 3,305.5 сая төгрөгийн хэмнэлттэй байгаа ба энэ нь төсөвт байгууллагуудын зарцуулагдаагүй үлдэгдэл, дутуу санхүүжсэн зардлын хэмнэлт байна.

2.3.9. Орон нутгийн төсвөөс санхүүждэг төсөвт байгууллагуудын урсгал зардлыг 17,499.1 сая төгрөгөөр баталж, 17,217.3 сая төгрөгийг зарцуулж, 98.4 хувийн гүйцэтгэлтэй байна. Зарцуулагдаагүй зардлын хэмнэлт 281.8 сая төгрөг, давсан орлогын үлдэгдэл 24.2 сая төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн байна.

2.3.10. Тусгай шилжүүлгээр санхүүждэг байгууллагын нийт зардлын батлагдсан төсөв 34,648.8 сая төгрөг бөгөөд 33,985.2 сая төгрөгийг зарцуулан 98.1 хувийн гүйцэтгэлтэй байна. Зарцуулагдаагүй зардлын хэмнэлт, давсан орлогын үлдэгдэл 595.8 сая төгрөгийг төвлөрүүлснээс, улсын төсөвт 264.8 сая төгрөгийг, орон нутгийн төсөвт 331.0 сая төгрөгийг тус тус төвлөрүүлсэн байна.

Тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагын 2019 оны батлагдсан төсөв, гүйцэтгэл

Хүснэгт №17

сая төгрөгөөр

№	ТЗШ-ийн байгууллага	Батлагдсан	Гүйцэтгэл	Давсан/ тасарсан орлого	Төвлөрүүлсэн
1	ЕБСургууль	19,209.4	18,869.7	0.6	340.3
2	Хүүхдийн цэцэрлэг	10,016.4	9,816.0	(0.3)	200.2
3	ЭМТөв	4,680.9	4,558.7	(70.3)	51.9
4	ГХБХБГ	402.5	401.5	-	0.9
5	ГБХЗХГ	339.6	339.3	2.2	2.5
	Нийт	34,648.8	33,985.2	(67.7)	595.8

2.3.11. Монгол Улсын 2019 оны төсвийн тухай хууль, аймгийн ИТХ-ын 2018 оны 9/08 дугаар тогтоолоор аймгийн төсвөөс 124.1 сая төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлэхээр батлагдсан ба үүнийг бүрэн төвлөрүүлсэн байна.

2.3.12. Эрүүл мэндийн даатгалын сангийн санхүүжилтийг 254.7 сая төгрөгөөр баталж, гүйцэтгэлээр 183.3 сая төгрөгийн санхүүжилтийг авч, 71.4 сая төгрөгөөр дутуу санхүүжигдсэн байна.

2.3.13. Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, 16 дугаар зүйлийн 16.5.3, 16.5.5 дахь заалтуудыг бүрэн мөрдөөгүйгээс зардлыг зориулалт бусаар зарцуулсан дараах зөрчил илэрлээ. Тухайлбал:

- Албан тушаалтны гэм буруутай үйлдлээс хууль бусаар ажлаас халагдсан ажилтны ажилгүй байх үеийн цалинг Айраг сумын ЕБС 1.1 сая төгрөг, Замын-Үүд сумын ЗДТГ 12.0 сая төгрөгийг төсвөөс олгож, төрд учирсан хохирлыг барагдуулаагүй. Уг зөрчлийг арилгуулахаар 2 төлбөрийн акт тогтоож, холбогдох албан тушаалтанд хүргүүлсэн.
- Засан даргын хөтөлбөр хэрэгжүүлэх зардлаас аймгийн үндсэн чиглэлд тусгагдаагүй 9 ТАХ-д 36.8 сая төгрөгийг зарцуулсан.
- Аймгийн ЗДТГ нь бага үнэтэй түргэн элэгдэх, ахуйн эд зүйлийн болон урсгал засварын зардлаас үндсэн хөрөнгө худалдан авсан.
- Алтанширээ сумын ЗДТГ, ЕБС нь үндсэн цалин болон түлш халаалтын зардлаас албан хаагчдад түлээ нүүрний хөнгөлөлт үзүүлсэн.
- Орон нутгийн төсвөөс ТЗШ-ийн байгууллагад олгосон байр ашиглалттай холбоотой тогтмол зардлаас Сайншанд сумын 10-р цэцэрлэг урсгал засварын зардлаас 0.3 сая төгрөгийг хоол хүнсний зардалд, Эрдэнэ сумын цэцэрлэг 0.7 сая төгрөгийг тоног төхөөрөмж худалдан авахад, Сайншанд сумын 9-р цэцэрлэг 0.2 сая төгрөгийг хөрөнгө худалдан авахад, Эрдэнэ сумын ЕБС 0.7 сая төгрөгийг тоног төхөөрөмж худалдан авахад зарцуулсан.

2.3.14. Төсөвт байгууллагууд батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулсан боловч хөрөнгө оруулалтын зардлаар чиг үүрэгт хамаарахгүй, холбогдох зөвшөөрөлгүй, гүйцэтгэлийг хянан баталгаажуулаагүй ТАХ-г санхүүжүүлсэн байна.

2.3.15. Аймгийн орон нутгийн хөрөнгө оруулалтаар тайлант оны 66 ТАХ, өмнөх оноос шилжиж ирсэн 15 нийт 81 төсөл арга хэмжээний зардалд 8,390.3 сая төгрөг батлагдаж, гүйцэтгэлээр 8,119.6 сая төгрөгийг, Замын-Үүд сумын орон нутгийн хөрөнгө оруулалтаар 21 төсөл арга хэмжээний зардалд 1,035.5 сая төгрөг батлагдаж 1,033.6 сая төгрөгийг тус тус зарцуулан, зардлын үлдэгдэл 272.6 сая төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн байна.

2.3.16. Орон нутгийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих 1,532.9 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 10 ТАХ зураг төсөвгүй, газрын зөвшөөрөлгүй 290.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 2 ТАХ баталсан байна. Мөн хөрөнгө оруулалтын бус шинжтэй 4 ТАХ-д 75.0 сая төгрөг, ажлын гүйцэтгэлийг хянан баталгаажуулаагүй ТАХ-д 6,954.3 сая төгрөгийг тус тус олгосон байна. Санхүүжилтийг олгож, ажлыг хүлээн авсан боловч 589.8 сая төгрөгийн 2 ТАХ дэд бүтцийн асуудал шийдэгдээгүй байгаа шалтгаанаар ашиглалтгүй байна.

2.4. Нэмэлт санхүүжилтийн дансаар хөрөнгө оруулалтын зарим ТАХ-ний санхүүжилтийг олгосон байна.

Нэмэлт санхүүжилтийн нэгтгэсэн тайлангаар тус дансанд дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө 602.4 сая төгрөг, төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 4,150.5 сая төгрөгийн орлогын эх үүсвэр төвлөрч, 4,446.2 сая төгрөгийг зарцуулсан ба зарцуулаагүй үлдэгдэл 302.8 сая төгрөгийг орон нутгийн болон улсын төсөвт төвлөрүүлж, өрхийн ЭМТ-ийн арилжааны банкны харилцах дансанд 3.9 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Өмнөх онтой харьцуулахад зардал 1,262.2 сая төгрөгөөр буюу 39.6 хувиар өссөн байна.

Нэмэлт санхүүжилтийн гүйцэтгэл

Хүснэгт №18

сая төгрөгөөр

№	Зардлын үзүүлэлт	Дүн	Зардлын нэр	Дүн	Хувь
1	Урсгал зардал	2,355.9	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	62.8	1.3%
2			Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	7.7	0.2%
3			Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	3.8	0.1%
4			Хангамж, бараа материалын зардал	162.0	3.4%
5			Нормативт зардал	8.2	0.2%
6			Эд хогшил, урсгал засварын зардал	312.6	6.6%
7			Томилолт, зочны зардал	33.4	0.7%
8			Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	969.1	20.4%
9			Бараа үйлчилгээний бусад зардал	407.8	8.6%
10			Урсгал шилжүүлэг	388.5	8.2%
11	Хөрөнгийн зардал	2,393.1	Барилга байгууламж	2,176.4	45.8%
12			Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	216.7	4.5%
Дүн		4,749.0		4,749.0	100%

Нийт зардлын 2,355.9 сая төгрөг буюу 49.6 хувийг урсгал зардалд, 2,393.1 сая төгрөг буюу 50.4 хувийг хөрөнгийн зардалд зарцуулжээ.

Төсвийн тухай хуулийн 46 дугаар зүйл, 47 дугаар зүйл болон Сангийн сайдын 2019 оны 74 дүгээр тушаалаар батлагдсан “Төсвийн зардлын хэмнэлт, үндсэн үйл ажиллагааны

нэмэлт орлогыг зарцуулах, тайлагнах, НББ-д тусгах, хяналт тавих журам"-д заасны дагуу төсөвт байгууллагууд нь нэмэлт дансанд төвлөрсөн орлогыг зарцуулах хүсэлтийг холбогдох баримтын хамт аймгийн Санхүү, төрийн сангийн хэлтэст хүргүүлэн зарцуулах эрхийг нээлгэн зориулалтын дагуу зарцуулсан байна.

2.4.1. Аймгийн ГХБХБГ нь үндсэн үйл ажиллагааны орлогыг бодитой төлөвлөөгүйгээс давсан орлого болох 313.7 сая төгрөгийг нэмэлт санхүүжилтийн дансанд төвлөрүүлэн зарцуулсан байна.

2.4.2. Замын-Үүд сумын ЗДТГ нь улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн, эрх шилжүүлсэн ажил болох соёл спортын ордны санхүүжилт 1,976.4 сая төгрөг, ОНХО-аар хэрэгжсэн, эрх шилжүүлээгүй ажил болох автомашин худалдан авах ажлын санхүүжилт 13.0 сая төгрөг, мөн аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр хийгдсэн Мандах наран хорооллын дэд бүтцийн ажлын санхүүжилт 226.0 сая төгрөг, нийт 2,215.4 сая төгрөгийн санхүүжилтийг төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого дансанд тусгасан байна.

2.4.3. Сумдын ЗДТГ нь нэмэлт санхүүжилтийн дансаар дамжуулан нийт 163.5 сая төгрөгийн хандив тусламжийг тухайн сумын газар нутагт үйл ажиллагаа явуулдаг хуулийн этгээдээс авч, зарцуулсан байна. Энэ нь НАНБХАСЗАСЗУСТ хуулийн 17.1-д "Албан тушаалтан, төрийн болон орон нутгийн захиргааны байгууллага, нутгийн өөрөө удирдах байгууллага нийтийн хэрэгцээнд зориулан иргэн, хуулийн этгээдээс бэлэг, бусад санхүүгийн туслалцааг авах, хүсэхийг хориглоно", Төсвийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.2-т "Хуульд өөрөөр заагаагүй бол зөвхөн нийгмийн үйлчилгээ үзүүлдэг төсвийн байгууллага хандив тусламж авч болно", 25.5-д "... хандив тусламж өгсөн этгээд төсвийн байгууллагын хэрэгцээнд өөрийн барааг худалдах, ажил гүйцэтгэх, үйлчилгээ үзүүлдэг байх, байгууллагын ажилтны энэ хуулийн 25.4.2-т зааснаас бусад нийгмийн асуудлыг шийдвэрлэх зорилготой байх" гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

АУДИТЫН ДҮГНЭЛТ

Дорноговь аймгийн 2019 оны төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

- Аймгийн нийт орлого 32,725.7 сая төгрөг буюу 104.9 хувийн, нийт зардал 31,071.0 сая төгрөг буюу 95.6 хувийн гүйцэтгэлтэй байна.
- Аймгийн төсвийн суурь орлого 31,190.5 сая төгрөгөөр, суурь зарлага 23,510.1 сая төгрөгөөр баталж, үндсэн тэнцлийн ашгийг 7,680.4 сая төгрөгөөр төлөвлөсөн байна.
- Аймгийн төсвийн тэнцлийг 21.1 сая төгрөгийн алдагдалтай баталсан байна.
- Алтанширээ, Сайншанд сумд нь санхүүгийн дэмжлэгийн нэмэлт өөрчлөлтийг хэлэлцэн батлаагүй, 67.3 сая төгрөгийн санхүүжилтийг хуваарилан зарцуулсан байна.
- Орон нутгийн төсвөөс улсын төсөвт төвлөрүүлэхээр батлагдсан 124.1 сая төгрөгийг бүрэн төвлөрүүлсэн байна.
- Орон нутгийн хөгжлийн сангийн нэгдсэн сангаас 2,013.7 сая төгрөгийн орлогын шилжүүлэг, ЭМДС-аас 71.4 сая төгрөгийн санхүүжилт дутуу байна.
- Төсөвт байгууллагууд батлагдсан төсвөөс зарцуулагдаагүй зардлын үлдэгдэл болон давсан орлого болох нийт 1,174.4 сая төгрөгийг улс, орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн байна.
- Айраг, Даланжаргалан, Хатанбулаг Хөвсгөл сумд нь НАНБХАСЗАСЗУСТ хууль зөрчиж 148.5 сая төгрөгийн санхүүгийн туслалцаа, хандивыг нэмэлт санхүүжилтийн дансаар авч, зарцуулсан байна.
- Төсвийн тухай хуулийн 58 дугаар зүйлийн 58.2.17-д заасны дагуу ТЗШ-ээр санхүүждэг байгууллагуудын байрлаж байгаа барилгын ашиглалт, хамгаалалтын зардлыг үндэслэлгүй төлөвлөснөөс тайлант оны эцэст орон нутгийн төсөвт 331.0 сая төгрөгийг буцаан төвлөрүүлсэн байна.

Аймгийн ТЕЗ-ийн анхааралд толилуулах нь:

Аймгийн 2019 оны төсвийн гүйцэтгэлийн тайланд тусгасан 67,881.4 сая төгрөгийн орлого, 68,042.7 сая төгрөгийн зарлага, мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл 1,561.4 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 1,400.0 сая төгрөгийг аудитаар баталгаажууллаа.

ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ


**ДОРНОГОВЬ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР**
44103 Дорноговь аймаг, Сайншанд сум, 3 дугаар баг,
Нутгийн удирдлагын ордон, Утас/Факс: (976) 7052 3036,
И-мэйл: zdtg@dornogovi.gov.mn, Вэбсайт: dornogovi.gov.mn


2020.05.05 № 3/763
танай 2020.05.04 -ны № 1-6/406 -т

**ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ДАРГА Ч.АРИУНАА ТАНАА**

Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2019 оны төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудиттай холбоотой санал үгүй болно.

ДАРГА  Б.ГАНЗОРИГ

Ч. Ариунаа
2020.05.05


44 8021039


АУДИТЫН ЗӨВЛӨМЖ

Аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг дор дурдсан албан тушаалтанд зөвлөж байна. Үүнд:

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА Т.ЭНХТҮВШИН ТАНАА

1. Орон нутгийн төсвийг батлахдаа үр ашигтай, төлөвлөж, төсвийг алдагдалгүй батлах, Төсвийн төвлөрүүлэн захирагчийн батлагдсан төсөв, харьяа байгууллагуудын төсөвт хяналт тавих, батлагдсан төсвийн хуваарийн дагуу төсвийн зарцуулах эрхийг нээж, төсвийг хуваарилах

2. Соёлын болон тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагуудын байр ашиглалтын зардлын төсвийг тооцоо судалгаанд үндэслэн бодитой төлөвлөж байх.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:  Ч.АРИУНАА

АУДИТЫГ ГҮЙЦЭТГЭСЭН БАГИЙН ГИШҮҮД :

Ахлах аудитор

О.Нарангарав

Аудитор

У.Оюунтүлхүүр

Аудитор

Б.Уранбилэг

Аудитор

Т.Мөнхтогтох


ХЯНАСАН:

Аудитын менежер

Ч.Хэрлэнчимэг

Дарга, тэргүүлэх аудитор

Ч.Ариунаа



**АУДИТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХАМТРАН ОРОЛЦСОНД
ТАЛАРХАЛ ИЛЭРХИЙЛЬЕ.**



ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН АУДИТОРЫН
ТУШААЛ

2020 оны 05 сарын 06 өдөр

Дугаар А/12

Дорноговь аймаг, Сайншанд сум

Төсвийн ерөнхийлөн захирагчийн
2019 оны төсвийн гүйцэтгэлийн тайлан
баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1, 15 дугаар зүйлийн 15.1.2, 15.1.12, 15.2.2, 19 дүгээр зүйлийн 19.3.3, Монгол улсын ерөнхий аудиторын 2018 оны А/207 дугаар тушаалын 5 дугаар хавсралтын 2.4 дэх заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2019 оны төсвийн гүйцэтгэл”-д хийсэн санхүүгийн аудитын тайланг баталсугай.
2. Аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж, биелэлтийг 2020 оны 09 дүгээр сарын 25-ны өдрийн дотор ирүүлэхийг аймгийн Засаг даргад даалгасугай.
3. Аудитын тайланг Үндэсний аудитын газрын Санхүүгийн аудитын газар, Аймгийн Засаг даргад тус тус хүргүүлсүгэй.
4. Санхүүгийн аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аудитын менежер /Ч. Хэрлэнчимэг/-д үүрэг болгосугай.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ч.АРИУНАА

